



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/645

Номгон

Зочид төлөөлөгчдөд өгөх гарын бэлгэнд зориулж
“Язгуурын дээд урлагт хайрхан-1”, “Баянхонгор
аймгийн 20 сумын байгаль танин мэдэхүйн хөтөч
номын цомог” номуудыг худалдан авах тухай


Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зочид төлөөлөгчдөд өгөх гарын бэлгэнд зориулж зохиолч Б.Жавзандуламын “Язгуурын дээд урлагт хайрхан-1”, Ш.Чимгээгийн “Баянхонгор аймгийн 20 сумын байгаль танин мэдэхүйн хөтөч номын цомог” номуудыг худалдан авсугай.

2.Эдгээр номуудыг худалдан авахад зориулж, зохиолч Б.Жавзандуламд 2,000,000 (хоёр сая) төгрөг, Ш.Чимгээд 3,600,000 (гурван сая зургаан зуу) нийт 5,600,000 (таван сая зургаан зуун мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210505